

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/54 тоот тушаалаар батлагдсан заавар, журам, бүтцийн дагуу 2016 оны үйл ажиллагааг нэгтгэн тайлагнаж байна. Үүнд:

### ***Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар***

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь 2016 онд төрийн аудитын байгууллагын системийн хэмжээгээр дэвшүүлсэн “Урьд онд хийсэн аудитын арга зүйн шинэчлэл, мэдээллийн технологийн ололт амжилтыг бататган төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн туршлага, мэдлэг, ур чадварт тулгуурлан аудитын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэн, хянан удирдах тогтолцоог сайжруулж, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн, төлөвлөсөн ажлуудаа бүрэн биелүүллээ.

Ерөнхий аудиторовын 2015 оны 318 дугаар тушаалаар тус Аудитын газрын орон тоог 12 байхаар баталсны дагуу тэргүүлэх аудитор, аудитын менежер, жолооч тус бүр 1, ахлах аудитор 2, аудитор 2, шинжээч 5 зэрэг бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.




*Сэлэнгэ аймгийн Аудитын газрын хамт олон*

2016 онд 248 ажлын өдөр буюу 23808 хүн/цаг ажиллахаас санхүүгийн аудит болон бусад аудитын ачааллаас шалтгаалан дунджаар 30 хуанлийн өдөр буюу 2880 хүн/цаг илүү ажилласан байна.

Тайлант онд Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 3 гүйцэтгэлийн аудит, 6 нийцлийн аудит болон 308 байгууллагын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн бол аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд 3 гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Хийгдсэн аудитуудаар нийт 26,411.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 268,4 сая төгрөгийн төлбөрийн акт, 12,880.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага бичиж, биелэлтэд хяналт тавин ажилласнаар 262,0 сая төгрөгийн акт, 11,784.2 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлээд байна.



2015 оноос шилжин ирсэн акт, албан шаардлагын дүнг нэгтгэн авч үзвэл тайлант онд нийт 283,4 сая төгрөгийн акт, 12,138.5 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг ханган, актын биелэлт 97,6 хувьтай, албан шаардлагын биелэлт 91,7 хувьтай тайлагнагдлаа. Төлбөрийн актын биелэлтийг хангуулснаар тайлант хугацаанд орон нутгийн төсөвт 114,6 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.



Хийж гүйцэтгэсэн аудитуудын дүнд үндэслэн арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 62, бүртгэл тайлагналтай холбоотой 72, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 121, дотоод хяналтыг сайжруулах 69, бусад чиглэлээр 25 гэх мэтчилэн нийт 349 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсний 88,3 хувь нь биелэгдсэн дүн мэдээтэй тайлагнагдлаа.

Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь заалт, ҮАГ-аас өгсөн аргачлал, зааврын дагуу аймаг, сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоон аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2016 оны А/02, А/14 тоот тушаалуудаар баталгаажуулав. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 152,0 сая төгрөгөөр, тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 16,0-37,0 сая төгрөгөөр,
- Сумын ИТХ-ын сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 90,0 сая төгрөгөөр, тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 5,0-8,0 сая төгрөгөөр тус тус тогтоов.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь заалтын дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нам, нэр дэвшигчийн зарцуулсан зардлын дүн, хандивын талаарх мэдээллийг 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр нийтэд зарлан мэдээлэв.Үүнд:

- Аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд МАН нийт дүнгээр 42,7 сая төгрөгийг төвлөрүүлж, зарцуулсан бол АН ямар нэгэн орлого төвлөрүүлээгүй байна.
- Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд нийт 548,4 сая төгрөг төвлөрсний 76,1 сая төгрөг нь хуулийн этгээдээс, 426,0 сая төгрөг нь иргэдээс өгсөн хандив бол 46,3 сая төгрөг нь нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө байна.
- МАН-д 1,0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 16 иргэнээс 42,7 сая төгрөг төвлөрсөн байна.
- Нэр дэвшигчдэд 2,0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 8 хуулийн этгээдээс 76,1 сая төгрөгийн, 1,0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 193 иргэнээс 426,0 сая төгрөг тус тус төвлөрсөн байна.

Сумдын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нам, нэр дэвшигчийн зарцуулсан зардлын дүн, хандивын талаарх мэдээллийг 2016 оны 12 сарын 28-ны өдөр нийтэд зарлан мэдээлэв.Үүнд:

- Сумдын ИТХ-ын ээлжит сонгуульд МАН нийт 8,5 сая төгрөгийн, АН нийт 16,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулсан байна.
- Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд нийт 321,5 сая төгрөг төвлөрсний 5,9 сая төгрөг нь хуулийн этгээдээс, 237,5 сая төгрөг нь иргэдээс өгсөн хандивын орлого бол 78,1 сая төгрөг нь нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө байна.
- МАН-д 1,0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 3 иргэнээс 8,5 сая төгрөг, АН-д 1 иргэнээс 1,0 сая төгрөгийн хандив төвлөрсөн байна.
- Нэр дэвшигчдэд 1,0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 58 иргэнээс 67,3 сая төгрөгийн хандив төвлөрсөн байна.

Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтын дагуу Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор мөрийн хөтөлбөрөө ирүүлсэн 6 улс төрийн нам, 19 бие даагчийн, сумын ИТХ-ын сонгуульд оролцохоор мөрийн хөтөлбөрөө ирүүлсэн 3 улс төрийн нам, 108 бие даагчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тус тус дүгнэлт гаргаж холбогдох Сонгуулийн хороодод хүргүүлээ.

Тайлант хугацаанд холбогдох хууль, тогтоол, шийдвэр, стандартыг ханган ажиллаагүйгээс санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь их хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдэж, **“Хязгаарлалттай санал дүгнэлт”** авсан болон аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг жил дараалан давтан гаргасан 17 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу

хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг бүрэн хангуулав.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт биелүүлээгүй 4 байгууллага, албан тушаалтнаар төлбөрийг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг Иргэний хэргийн шүүхэд гарган барагдуулсан болно.

2016 онд нийт 4.801,2 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн харилцагчдаар хүлээн зөвшөөрүүлэв.

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь хийж гүйцэтгэсэн аудитын дүн, илрүүлсэн алдаа зөрчил, өгсөн зөвлөмжийг хэрэглэгчдэд нээлттэй, ил тод мэдээлэх зарчмын хүрээнд аудитын тайлангууд, цаг үеийн ажлууд болон байгууллагын танилцуулга, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангуудыг AUDIT.MN цахим хуудсанд оруулаад байгаа бөгөөд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, холбогдох бусад үзүүлэлтүүдийг хуулийн хугацаанд нь SHILENDANS.GOV.MN нэгдсэн цахим хуудсанд мэдээлж ирлээ.

Мөн аймгийн ИТХ-ын дарга, бүх гишүүдэд цахимаар, аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга, Хөгжлийн бодлогын болон СТС-ийн хэлтсийн дарга нар, аудит хийгдсэн байгууллагуудад аудитын тайланг хэвлэн хүргүүлж байна.

Сэлэнгийн мэдээ сонин, Миний монгол кабелийн телевиз зэрэг орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад аудитын тайланг бүрэн эхээр нь электрон шуудангаар тогтмол хүргүүлж ирлээ.

Сэлэнгэ аймгийн Аудитын газраас холбогдох хууль<sup>1</sup>, журмын<sup>2</sup> дагуу төрийн өмчийн 1, орон нутгийн өмчийн 10 аж ахуйн нэгж болон 3 МСҮТ, боловсрол, эрүүл мэндийн салбарын 57 байгууллага зэрэг нийт 71 байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийлгэхээр хараат бус аудитын 5 компанитай гурвалсан гэрээ байгуулж, “Эрхийн бичиг” олголоо.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/50 дугаар тушаалын дагуу ҮАГ-ын Чанарын баталгаажуулалтын албаны дарга Г.Цэдэнбалжир, ахлах аудитор Г.Юра нар 2016 оны 09 дүгээр сарын 08-наас 12-ны өдрүүдэд тус Аудитын газарт ажиллан аудитын үе шатны ажлуудад чанарын баталгаажуулалт хийж, арга зүйн зөвлөгөө өгснийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



<sup>1</sup> МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дахь заалт

<sup>2</sup> МУ-ын Ерөнхий аудиторовын 2009 оны 108 тоот тушаалаар батлагдсан “Тэрээгээр аудит хийлгэх журам”


### Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 308 байгууллага, аж ахуйн нэгжийн 2015 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулахаар төлөвлөснөөс өөрийн аудитор, шинжээчдээр 244, хараат бус аудитын 4 компаниар 64 байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгүүллээ.

Аудитад хамрагдсан 308 байгууллагын 51-д нь Ерөнхий аудиторын тушаалаар итгэл үзүүлж, 101 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 156 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд бие даан дүгнэлт гаргасан байна.

Нийт дүгнэлт гаргасан байгууллагын 146-д нь “Зөрчилгүй”, 10-д нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,425.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,842.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 49.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,387.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 5,146.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.



**Актын биелэлт:** Өмнөх оны үлдэгдлийг бүрэн төлүүлж, тайлант онд тогтоогдсон актаас 46.1 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт 93.3 хувьтай тайлагнагдсан бөгөөд 3.7 сая төгрөгийн актын төлбөр дараа онд шилжээд байна.

**Албан шаардлагын биелэлт:** Тайлант хугацаанд санхүүгийн аудитаар нийт 1,387.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн бөгөөд 1,283.7 сая төгрөгийн зөрчлийг арилгасан талаар харилцагч байгууллагуудаас хариу ирүүлж, албан шаардлагын биелэлт 92.5 хувьтай тайлагнагдлаа. 103.8 сая төгрөгийн албан шаардлагын биелэлт тооцох хугацаа хараахан болоогүй байна.

График №5



Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 14 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өгч хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.

**Зөвлөмжийн хэрэгжилт:** Аудитаар арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 41, бүртгэл тайлагналтай холбоотой 56, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 56, дотоод хяналтыг сайжруулах 45 зэрэг нийт 238 зөвлөмж өгснөөс 212 зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай хариу ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 89.1 хувьтай байна.

Санхүүгийн аудитаар 533.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож харилцагчаар хүлээн зөвшөөрүүлсэн болно.

### Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

Тайлант онд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр “Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”, “МУ-ын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”, “УИХ-ын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл” сэдэвт

3 аудит, аймгийн ИТХ-ын захиалгаар болон өөрийн төлөвлөгөөгөөр 3 аудит зэрэг нийт 6 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ.


**Актын биелэлт:** Өмнөх оны үлдэгдлээс 15.7 сая төгрөгийг, тайлант онд тогтоогдсон актаас 160.0 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт 98.2 хувьтай тайлагнагдсан бөгөөд 3.3 сая төгрөгийн актын төлбөр дараа онд шилжээд байна.

**Албан шаардлагын биелэлт:** Урьд оноос шилжиж ирсэн 38.0 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант хугацаанд 6,406.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгснөөс 5,781.9 сая төгрөгийн зөрчлийг арилгасан талаар харилцагч байгууллагуудаас хариу ирүүлж, албан шаардлагын биелэлт 90,3 хувьтай тайлагнагдлаа. 625,0 сая төгрөгийн албан шаардлагын биелүүлэх хугацаа хараахан болоогүй учир дараа онд шилжээд байна.

**Зөвлөмжийн хэрэгжилт:** Арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 16, бүртгэл тайлагналтай холбоотой 9, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

18, бусад 8, дотоод хяналтыг сайжруулах 8 зэрэг нийт 59 зөвлөмж өгсөн бөгөөд 86.4 хувь буюу 51 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

График №6



Өмнөх онд хэрэгжээгүйн улмаас он дамжсан 16 зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин ажилласнаар 100.0 хувь биелүүлээд байна.

Гүйцэтгэлийн аудитаар 3,140.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

### **Дөрөв. Нийцлийн аудитын талаар**

Тайлант хугацаанд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр дараах 6 нийцлийн аудит хийж гүйцэтгэв. Үүнд:

1. *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт*
2. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт /1-р улирлын байдлаар/*
3. *Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилт*
4. *Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн*
5. *Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл*
6. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт /3-р улирлын байдлаар/*


Нийт хийж гүйцэтгэсэн нийцлийн аудитаар 55.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,082.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 392.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах талаар 52 зүйлийн зөвлөмж өгсөн байна.

**Актын биелэлт:** Өмнөх оноос шилжсэн актын үлдэгдэл байхгүй ба тайлант хугацаанд тогтоосон 55,9 сая төгрөгийн актыг бүрэн барагдуулаад байна.

**Албан шаардлагын биелэлт:** Өмнөх оноос шилжиж ирсэн 316,3 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант онд тавигдсан 5,086.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагын 4,718.6 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авсан талаар харилцагч байгууллагуудаас хариу ирүүлснээр албан шаардлагын биелэлт 93,3 хувьтай тайлагнагдлаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 3-р улирлын байдлаар хийгдсэн аудитаар тогтоогдсон 367,6 сая төгрөгийн албан шаардлагын хугацаа болоогүй тул дараа онд шилжсэн болно.

График №7



Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өгснийг 100 хувь биелүүлж, сахилгын шийтгэл ногдуулсан байна.

**Зөвлөмжийн хэрэгжилт:** Арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 5, бүртгэл тайлагналтай холбоотой 7, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 18, дотоод хяналтыг сайжруулах 16, бусад 6 зэрэг нийт 52 зөвлөмж өгснийг 86,5 хувийг буюу 45 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллалаа.

Урьд оноос шилжиж ирсэн 10 зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар бүрэн биелсэн болно.

Нийцлийн аудитаар 1,127.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож харилцагчаар хүлээн зөвшөөрүүлэв.

**Тав. Аймгийн ИТХ-ын хүсэлтээр хийсэн аудит болон ИТХ-тай хамтран ажилласан талаар**

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын захиалга болон өөрийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэн аудитын тайлан, дүнг хүргүүлэв. Үүнд:

- Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, үр нөлөө,
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, ашиглалтын үр нөлөөт байдал,
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүн,

2016 онд хийгдсэн нийт 6 гүйцэтгэлийн аудитаас аймгийн ИТХ-ын захиалга болон өөрийн төлөвлөгөөгөөр хийсэн аудитуудын дүнг салган авч үзвэл:

**Актын биелэлт:** Тайлант хугацаанд 162,7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож 98,3 хувийг буюу 160,0 сая төгрөгийн актыг барагдуулаад байна.

**Албан шаардлагын биелэлт:** Нийт 3,627.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдсөнөөс 3,356.8 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлсэн талаар харилцагч байгууллагуудаас хариу ирүүлсэн бөгөөд албан шаардлагын биелэлт 92,5 хувьтай тайлагнагдлаа.

**Зөвлөмжийн хэрэгжилт:** Арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 9, бүртгэл тайлагналтай холбоотой 4, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 4, дотоод хяналтыг сайжруулах 4, бусад 3 зэрэг нийт 24 зөвлөмж өгсний 67,7 хувийг буюу 16 зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелүүлэх хугацаа болоогүй 8 зөвлөмж дараа онд шилжсэн болно.

Дээрх аудитуудаар нийт 3,080.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагчаар хүлээн зөвшөөрүүлэв.

**Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь 2016 онд аймгийн ИТХ-ын нэгдсэн хуралдаанд дараах асуудлуудыг оруулж хэлэлцүүллээ. Үүнд:**

1. Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Сэлэнгэ аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын дүн",
2. Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хийсэн аудитын тайлан, анхаарал татах асуудлуудын талаарх мэдээлэл,
3. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Аймаг хөгжүүлэх сангаас олгосон эргэн төлөх хугацаа хэтэрсэн 4092,0 сая төгрөгийн зээлийн талаарх дүгнэлт, мэдээлэл,
4. Төрийн аудитын тухай хуулийн 15.2.4-дэх "Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулах" гэсэн бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргаас 2016 оны 12 сарын 02-нд хуралдсан аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн 2017 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардал бууруулах санал боловсруулж хэлэлцүүлэв.
5. Аймгийн Аудитын газрын бүтэц, үйл ажиллагаа, ажиллагсдын талаарх мэдээллийг шинээр байгуулагдсан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан, сонирхсон асуултад хариу өгөв.

### **Зургаа. Дотоод ажлын талаар**

2016 онд аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 30 тушаал гарч, явсан бичиг 270, ирсэн бичиг 165 тус тус бүртгэгджээ.

Аудитор, шинжээчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд авч, тайлан, мэдээг хүргүүлэв.

Аудит хийж гүйцэтгэх тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг ажилтнуудаар гаргаж, баталгаажуулж байна.

Тэргүүлэх аудиторын зүгээс аймгийн Аудитын газрын аудитор, шинжээчидтэй үр дүнгийн гэрээ, үйлчилгээний ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр дүгнэн ажиллалаа.

Аймгийн Аудитын газрын, техник тоног, төхөөрөмж, албан ажлын авто машинуудад тухай бүрд нь холбогдох үйлчилгээ хийж, ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангав.

Холбогдох байгууллагуудад санал хүсэлт гаргаж, иж бүрэн компьютер 1 ширхэг болон цахим хурал, сургалтын тоног төхөөрөмжөөр хангагдлаа.

Аймгийн Засаг даргад хүсэлт гаргаснаар аймгийн Аудитын газар байрладаг барилгын сантехникийн шугамд их засвар хийлгэн, ажиллах нөхцөл, боломжийг сайжруулав.

### **Сургалт, зөвлөгөөн :**

#### **ҮАГ-аас зохион байгуулсан:**

- 03-р сард төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, сургалтад дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа оролцсон болно.
- 03 сард Нийцлийн аудитын газраас зохион байгуулсан “Аймгийн ИТХ-ын сонгуульд нам, эвсэл нэр дэвшигчийн зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай “ цахим сургалтад тэргүүлэх аудитор, аудитын менежер зэрэг 4 хүн хамрагдав.
- 06-р сард “СТАУС-ийг хөгжүүлэх зарим асуудал”-аар төрийн аудитын төв, орон нутгийн ажилтнуудын дунд зохион байгуулсан хэлэлцүүлэгт дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитын менежер Б.Батмөнх, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор Б.Эрдэнэзул нар оролцов.



- “Аудитын Дээд байгууллагын олон улсын стандарт”-ын сургалтад аудитын газрын бүх аудитор, шинжээчид хамрагдсан болно.



### **Бусад сургалт**

- 04-р сард аймгийн ЗДТГ-аас Хууль зүйн яамтай хамтран зохион байгуулсан Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн талаарх сургалтад тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, шинжээч Ж.Цогт нар хамрагдав.
- 4-р сард Хүн ам, нийгмийн хамгааллын яам, НДЕГ-аас зохион байгуулсан Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэлийн талаарх сургалтад тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитор Б.Эрдэнэзул нар хамрагдав
- 05-р сард Сангийн яамны ТӨУБТХ-аас зохион байгуулсан төрийн болон орон нутгийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай сургалтад нягтлан бодогч Б.Эрдэнэзул оролцсон.
- 04-р сард ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, 11-р сард аудитор Ц.Отгонбаяр нар ММНБИ-ийн эрх сунгах 14 хоногийн сургалтад хамрагдаж “Хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогч” болов.
- АТГ-аас зохион байгуулсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг танилцуулах, “Орон нутагт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарах асуудал”, “Хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, орон нутгийн удирдлагын хэмжээнд анхаарах зарим асуудлууд” сэдэвт сургалтад нийт ажилтнууд хамрагдлаа.
- 01-р сард мэдээллийн технологи хариуцсан шинжээч Э.Эрдэнэзул мэдээллийн технологийн аюулгүй байдал, оффисын хэрэглээний программуудын тухай болон дотоод сүлжээний талаар нийт аудитор, шинжээчдэд сургалт явуулав.
- Сэлэнгэ аймгийн Архивын газарт хүсэлт гаргасны дагуу 05 сард зохион байгуулсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар болон баримт бичгийн стандартын үндсэн ойлголт” сэдэвт сургалтад бүх аудитор, шинжээчид хамрагдав.
- Шинжээч Б.Эрдэнэзул, Ж.Цогт нар Мандах бүртгэлийн дээд сургуулийн Дархан-Уул дахь салбарыг нягтлан бодогч мэргэжлээр төгсөв.

### **Албан харилцаа**

- Төр, төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2015 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийхтэй холбогдуулан төсвийн захирагчид, нягтлан бодогчдод мэдээлэл өгөв.
- Гүйцэтгэж байгаа аудитын талаар ҮАГ-ын холбогдох албан тушаалтнуудаас тухай бүр зааварчилга авснаас гадна зохион байгуулж буй цахим хуралд бүрэн оролцож аудитын явц, үр дүнгийн талаар мэдээлэл хийж ирлээ.
- Миний Монгол кабелийн телевизээс зохион байгуулдаг “Иргэдээ сонсоё” нэвтрүүлэгт Аудитын газрын удирдлагын зөвлөлийн гишүүд оролцож 2015 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн талаар мэдээлэл хийж, иргэдийн сонирхсон асуултад хариу өгөв.
- Дундговь, Дорноговь, Хөвсгөл, Сүхбаатар аймгийн Аудитын газрын ажилтнууд Сэлэнгэ аймгийн Аудитын газрын үйл ажиллагаатай танилцаж, санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн, нийцлийн аудитын талаар санал бодлоо ярилцаж, харилцан туршлага солилцов.
- ТАБ-ын ажилтнуудаас авах мэргэшлийн шалгалтын журмын дагуу ахлах аудитор Б.Наранчимэг төстийн болон ур чадварын шалгалтад хамрагдаж “онцгой сайн” буюу 95.0 оноотой үнэлэгдэв.

### **Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:**

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Аудитын газарт ирүүлсэн дараах өргөдлийг шийдвэрлэж, хариу өгөв. Үүнд :

- Нэмэгдэл цалин, хөлстэй холбоотойгоор Сүхбаатар сумын 2-р бүрэн дунд сургуулиас ирүүлсэн өргөдөл,
- Үндсэн болон нэмэгдэл цалин хөлсийг дутуу бодож байгаа талаар Сайхан сумын бүрэн дунд сургуулийн хэсэг багш нараас ирүүлсэн өргөдөл,
- Аймгийн ХХААГ-т шилжүүлсэн хөрөнгийн ашиглалттай холбоотойгоор Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ салбараас ирүүлсэн өргөдөл,

### **Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл**

Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагаанд 210,0 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд албан томилолт, шатахуун, бичиг хэрэг, шуудан холбооны зардалд нэмж 15,1 сая төгрөгийг тодотгон, нийт 225,1 сая төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 224,7 сая төгрөг зарцуулж, 0,4 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдлаа.

Нийт зардлын гүйцэтгэлийн 87,4 хувийг цалин, НДШ-ийн зардал, 12,6 хувийг бараа үйлчилгээний урсгал зардал эзэлж байна.

График №8



2016 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогыг Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2016 оны 07 тоот тушаалаар томилогдсон комисс хийж гүйцэтгэн, дүн мэдээг нэгтгэн УАГ-т хүргүүлэв. Уг үзлэг, тооллогоор Сэлэнгэ аймгийн Аудитын газрын үйл ажиллагаанд 23,2 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 65,0 сая төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, 8,8 сая төгрөгийн үнэ бүхий эд хогшил, бусад 0,6 сая зэрэг нийт **97,6 сая** төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгө тоологдлоо.

Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулж Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2016 оны 30 дугаар тушаалаар томилогдсон “Эд хөрөнгийн тооллогын комисс” хөрөнгийн тооллого явуулж, эзэмшүүлэх картыг шинэчлэн хөтлөв.

### Наймдугаар бүлэг. Дүгнэлт

*Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь “Төрийн аудитын үйл ажиллагааг хараат бус, шударга, мэргэжлийн, найдвартай зарчмын дагуу гүйцэтгэж, төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж, 2016 оны зорилтоо бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.*

ТАЙЛАН БИЧСЭН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА